

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Цэвэр хот ОНӨААТҮГ -ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/005/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2025.03.15</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер М.Алтантуяа Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Аудитор Ц.Дорж Утас: 88114307 Цахим хаяг: Dorjts@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	11
3.3 Сайнхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТОУС	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт





ЦЭВЭР ХОТ ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА П.УРТНАСАН ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2025.03.15 № 2/91
танай _____-ны № _____-т

Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянхонгор аймгийн Цэвэр хот ОНӨААТҮГ -ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Аудитаар 276,556.1 мянган төгрөгийн шатах тослох материал худалдан авахдаа худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүй шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн байна.

- Тайлант онд бараа материал худалдан авахдаа 395,786.1 мянган төгрөгийн И баримт шивүүлээгүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1 дэх "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж

5020426

болно", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дүгээр зүйлийн 17.6 дахь "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 12/73 дугаар Хуралдааны Тогтоолоор хог хаягдлын үнэ тарифыг шинэчлэн баталж захиргааны хэм хэмжээний актын 6543 дугаарт бүртгүүлэн 2024 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 18 -ны 12/76 дугаар тогтоолоор тус байгууллагын хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөөг 1,292,900.0 мянган төгрөгөөр баталж, 2024 оны 09 дүгээр сарын 25 -ны өдрийн 16/96 дугаар тогтоолоор 140,000.0 мянган төгрөг нэмэгдүүлэн баталж, Баянхонгор сумын Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 01 -ний өдрийн А/271 дүгээр захирамжаар төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан байна.

Тайланд онд 42,175.9 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт, 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 93.6 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>53,090,561.6</u>	<u>52,189,494.0</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	30,200.4	923,142.8
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	30,200.4	923,142.8
3121	Төгрөг	30,200.4	923,142.8
31213	Арилжааны банк дахь харилцах	30,200.4	923,142.8
33	АВЛАГА	2,534,590.2	2,534,590.2
33401	Дансны авлага /ТӨҮГ/	1,080,000.0	1,080,000.0
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	1,454,590.2	1,454,590.2
35	БАРАА МАТЕРИАЛ	50,525,771.0	48,731,761.0
354	Хангамжийн материал	49,145,771.0	47,351,761.0
35410	Бичиг хэргийн материал	884,680.0	1,096,290.0
35420	Аж ахуйн материал	45,962,251.0	44,294,771.0
35430	Сэлбэг хэрэгсэл	2,298,840.0	1,960,700.0
35600	Мал амьтад	1,380,000.0	1,380,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>515,650,083.4</u>	<u>535,989,871.1</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	515,650,083.4	535,989,871.1
392	Биет хөрөнгө	477,430,083.4	497,769,871.1
39201	Барилга, байгууламж, орон сууц	17,220,049.0	17,220,049.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	10,332,029.4	12,054,034.3
39203	Авто-тээврийн хэрэгсэл	717,740,333.0	797,770,333.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	429,241,138.9	452,867,142.8
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	8,054,000.0	20,425,000.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	3,995,777.8	7,452,777.8
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,112,800.0	6,590,900.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	8,211,633.4	4,487,566.7
39214	Бусад үндсэн хөрөнгө	219,116,851.0	219,116,851.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	44,033,370.2	86,491,740.4
393	Биет бус хөрөнгө	38,220,000.0	38,220,000.0
39301	Програм хангамж	869,000.0	869,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	869,000.0	869,000.0
39303	Бусад биет бус хөрөнгө	38,220,000.0	38,220,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>568,740,645.0</u>	<u>588,179,365.1</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>102,265,073.2</u>	<u>79,527,933.6</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	102,265,073.2	79,527,933.6
413	Өглөг	102,265,073.2	79,527,933.6
4136	Бусад өглөг	102,265,073.2	79,527,933.6
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	20,179,176.8	26,184,864.3
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	49,161,834.0	19,161,536.2
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	32,924,062.4	34,181,533.1

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЭЛТ

**Баянхонгор аймгийн Цэвэр хот ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	466,475,571.8	508,651,431.5
51	Засгийн газрын хувь оролцоо	466,475,571.8	508,651,431.5
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	612,440,438.0	612,440,438.0
51101	Өмч: - төрийн	612,440,438.0	612,440,438.0
512	Хуримтлагдсан үр дүн	(145,964,866.2)	(103,789,006.5)
51210	Өмнөх үеийн үр дүн	(15,408,320.6)	(145,964,866.2)
51220	Тайлант үеийн үр дүн	(130,556,545.6)	42,175,859.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	568,740,645.0	588,179,365.1

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	860,641,183.0	1,567,887,430.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	860,641,183.0	1,567,887,430.0
120	Нийтлэг татварын бус орлого	860,641,183.0	1,567,887,430.0
120009	Бусад орлого	40,470,333.0	122,130,000.0
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	820,170,850.0	1,445,757,430.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	991,197,728.6	1,525,711,570.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	991,197,728.6	1,525,711,570.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	991,197,728.6	1,525,711,570.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	991,197,728.6	1,525,711,570.3
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	291,197,728.3	381,054,282.6
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	235,400,123.0	631,704,501.5
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	364,565,211.0	366,972,276.2
210813	Бусад зардал /ТӨҮГ/	100,034,666.3	145,980,510.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(130,556,545.6)	42,175,859.7
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(130,556,545.6)	42,175,859.7

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	612,440,438.0	-369,124,148.9	243,316,289.1
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	612,440,438.0	-369,124,148.9	243,316,289.1
C07	Тайлант үеийн үр дүн		223,159,282.7	223,159,282.7
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	612,440,438.0	-145,964,866.2	466,475,571.8
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	612,440,438.0	-145,964,866.2	466,475,571.8
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	612,440,438.0	-145,964,866.2	466,475,571.8

**Баянхонгор аймгийн Цэвэр хот ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

D08	Тайлант үеийн үр дүн	0.0	42,175,859.7	42,175,859.7
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	612,440,438.0	-103,789,006.5	508,651,431.5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	820,170,850.0	1,446,652,030.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	820,170,850.0	1,446,652,030.0
120	Нийтлэг татварын бус орлого	820,170,850.0	1,446,652,030.0
120009	Бусад орлого	31,370,850.0	13,752,030.0
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	788,800,000.0	1,432,900,000.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	820,743,571.7	1,445,759,087.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	820,743,571.7	1,445,759,087.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	820,743,571.7	1,445,759,087.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	346,088,447.1	631,704,501.5
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	346,088,447.1	631,704,501.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,000,000.0	212,537,907.1
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	47,000,000.0	212,537,907.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,501,018.0	9,706,200.0
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	11,501,018.0	9,706,200.0
2104	Хангамж, бараа материалын зардал	301,263,679.0	394,126,476.2
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	292,566,379.0	366,972,276.2
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	8,697,300.0	27,154,200.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	114,890,427.7	197,684,002.8
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	8,988,977.7	51,703,492.8
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	105,901,450.0	145,980,510.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(572,721.7)	892,942.4
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(572,721.7)	892,942.4
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	602,922.1	30,200.4
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	30,200.4	923,142.8



2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Д/Д	Зардал	2024 он		Хэтрэлт, хэмнэлт	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	30,200.4	923,142.8	(892,942.4)	3,056.7
2	УРСГАЛ ЗАРДАЛ	1,432,900,000.0	1,445,859,087.0	(12,959,087.0)	100.9
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,422,960,000.0	1,439,252,587.0	(16,292,587.0)	101.1
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	872,164,000.0	695,278,240.0	176,885,760.0	85.6
5	Үндсэн цалин	872,164,000.0	695,278,240.0	176,885,760.0	79.7
7	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,520,500.0	212,537,907.0	(61,017,407.0)	140.3
8	Тэтгэврийн даатгал	151,520,500.0	212,537,907.0	(61,017,407.0)	140.3
9	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,538,500.0	17,608,452.0	(69,952.0)	100.4
10	Гэрэл, цахилгаан	4,106,500.0	4,106,452.0	48.0	100
11	Тулш, халаалт	3,400,000.0	3,400,000.0	-	100
12	Цэвэр, бохир ус	792,000.0	792,000.0	-	100
13	Байрны түрээс	9,240,000.0	9,310,000.0	(70,000.0)	100.8
14	Хангамж, бараа материалын зардал	258,878,400.0	294,606,436.0	(35,728,036.0)	113.8
15	Бичиг хэрэг	3,285,600.0	3,633,500.0	(347,900.0)	110.6
16	Тээвэр, шатахуун	248,513,200.0	283,698,036.0	(35,184,836.0)	114.2
17	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,557,600.0	1,557,600.0	-	100
18	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,522,000.0	5,717,300.0	(195,300.0)	103.5
19	Нормативт зардал	13,388,000.0	13,388,000.0	-	100
20	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,388,000.0	13,388,000.0	-	100
21	Эд хогшил, урсгал засварын зардал	84,952,900.0	121,233,240.0	(36,280,340.0)	142.7
22	Багаж, техник, хэрэгсэл	18,358,000.0	18,358,000.0	-	100
23	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	24,841,900.0	24,841,900.0	-	100
24	Урсгал засвар	41,753,000.0	78,033,340.0	(36,280,340.0)	186.9
27	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,717,700.0	19,717,700.0	-	100
29	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	750,000.0	750,000.0	-	100
30	Даатгалын үйлчилгээ	1,280,000.0	1,280,000.0	-	100
31	Тээврийн хэрэгслийн онишлогоо	704,000.0	704,000.0	-	100
32	Тээврийн хэрэгслийн татвар	1,840,000.0	1,840,000.0	-	100
33	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15,143,700.0	15,143,700.0	-	100
34	Бараа үйлчилгээний бусад зардал	4,800,000.0	64,882,612.0	(60,082,612.0)	1,351.7

**Баянхонгор аймгийн Цэвэр хот ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

35	Бараа үйлчилгээний бусад зардал	-	64,320,612.0	(64,320,612.0)	
36	Гэрээт зардал	4,800,000.0	562,000.0	4,238,000.0	11.7
37	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,940,000.0	6,606,500.0	3,333,500.0	66.5
38	Бусад урсгал шилжүүлэг	9,940,000.0	6,606,500.0	3,333,500.0	66.5
39	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,940,000.0	6,606,500.0	3,333,500.0	66.5
43	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,432,900,000.0	1,445,819,600.0	(12,919,600.0)	100.9
44	Санхүүгийн дэмжлэг	1,292,900,000.0	1,292,900,000.0	-	100
45	Давсан орлого	140,000,000.0	140,000,000.0	-	100
46	Бусад орлого	-	12,919,600.0	(12,919,600.0)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани /ТӨҮГ/, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Цэвэр хот ОНӨААТҮГ нь “Хог хаягдлыг төвлөрсөн журмаар ачиж тээвэрлэн, нэгдсэн хогийн цэгт хүргэн, дарж булшилж хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, дахин ашиглахтай холбоотой иргэд, аж ахуй нэгж байгууллагын нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэн хог хаягдлыг ангилан ялгаж цуглуулахтай холбоотой харилцааг зохицуулж, байгаль орчинд ээлтэй цэвэр орчныг бүрдүүлсэн өндөр мэдлэг, ур чадвартай, сахилга хариуцлагыг эрхэмлэсэн төрийн үйлчилгээний нийтлэг албыг хөгжүүлэхээр” эрхэм зорилгоо болгосон

Тус компани нь 2024 онд Захиргаа аж ахуйн хэсэг, Тээвэрлэлт засвар үйлчилгээ, нохой муур устгалын хэсэг, Орон сууцны цэвэрлэгээ үйлчилгээний хэсэг гэсэн 3 хэсэгтэй 60 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан.

2024 онд гэр хорооллын 9.283 өрх, орон сууцны 2.290 өрх, төрийн 54, хувийн хэвшлийн аж ахуй нэгж 153 хүнсний дэлгүүр 148 хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс 12 дугаар сарын байдлаар төвлөрсөн хогийн цэгт газрын хог тээврийн 14 авто машинаар 4.888 удаагийн рейсээр нийт 39.096 тн хог хаягдлыг тээвэрлэж, нэгдсэн хогийн цэгт 60 удаагийн түрэлтийг хийж дарж булшлах үйл ажиллагааг зохион байгуулж зорилтот түвшинг давуулан биелүүлсэн.

3.2 Компани /ТӨҮГ/-ын гадаад, дотоод орчин

“Цэвэр хот” ОНӨААТҮГ нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус компани нь санхүүгийн үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг ашигладаггүй санхүүгийн Leader-3, цалингийн Payroll программ ашигладаг.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаанд, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.



Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 12/73 дугаар Хуралдааны Тогтоолоор хог хаягдлын үнэ тарифыг шинэчлэн баталж захиргааны хэм хэмжээний актын 6543 дугаарт бүртгүүлэн 2024 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн.

“Цэвэр хот” ОНӨААТҮГ нь дотоод аудитын нэгж байхгүй бөгөөд санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт дотоод аудитын алба хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Цэвэр хот ОНӨААТҮГ -ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компани нь Аймгийн санхүү, төрийн сангийн хэлтсээс 2021 онд гаргасан "Төсвийн байгууллага, төсөл сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Цэвэр хот ОНӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3-т Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19,438.8 мянган төгрөг буюу 3.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл	
	дүн	эзлэх хувь	дүн	эзлэх хувь	дүн	эзлэх хувь
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	53,090.6	9.3	52,189.5	8.9	(901.1)	(4.6)
МӨНГӨН ХӨРӨНГӨ	30.2	0.1	923.1	1.8	892.9	(99.1)
АВЛАГА	2,534.6	4.8	2,534.6	4.9	-	-
УРЬДЧИЛГАА	-	-	-	-	-	-

**Баянхонгор аймгийн Цэвэр хот ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

БАРАА МАТЕРИАЛ	50,525.8	95.2	48,721.7	93.4	-1804.1	200.2
НӨӨЦИЙН БАРАА	-		-		-	
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	515,650.1	90.7	535,989.9	91.1	20,339.8	104.6
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,012,333.0	90.7	1,100,212.1	91.1	87,879.1	104.6
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	(496,682.9)	(96.3)	(564,222.2)	(95.9)	(67,539.2)	(347.5)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	568,740.6	100	588,179.4	100.0	19,438.8	100.0
НИЙТ ӨР ТӨЛБӨР	102,265.0	18.0	79,527.9	13.5	(22,737.1)	(117.0)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	466,475.6	82.0	508,651.4	86.5	42,175.8	217.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	568,740.6	100	588,179.4	100.0	19,438.8	100.0

Мөнгө хөрөнгө дансны үлдэгдэл 923.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 892,9 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлага дансны үлдэгдэл 2,534.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос өөрчлөлт ороогүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 48,721.7 мянган төгрөг болж өмнөх оноос 1,804.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Төсвийн худалдан авалтаар Бичиг хэргийн материалд 3,633.5 мянган төгрөг, Сэлбэг хэрэгсэлд 78,123.6 мянган төгрөг, Түлш, шатах тослох материалд 276,556.1 мянган төгрөг, Аж ахуйн материалд 27,669.4 мянган төгрөгийн бараа материалыг орлогод авч. Бичиг хэргийн материал данснаас 3,421.9 мянган төгрөг, Аж ахуйн материал данснаас 29,336.9 мянган төгрөг, Сэлбэг хэрэгсэл данснаас 78,461.8 мянган төгрөг, Түлш, шатах тослох материал данснаас 276,556.1 мянган төгрөгийг материалыг зарцуулсан нь бараа материалын данс буурахад голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,100,212.1 мянган төгрөг болж 87,879.1 мянган төгрөгөөр өссөн нь Машин тоног төхөөрөмж дансанд Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 25 дугаар захирамжаар хог пресслэгч 1 ширхэг 9,900.0 мянган төгрөг, чанга яригч 15 ширхэг 2,700.0 мянган төгрөг, Тээврийн хэрэгсэл дансанд 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 99 дүгээр захирамжаар хогны машины 1 ширхэг 100,000.0 мянган төгрөг, БНХАУ-ын Гансу мужийн эзний хошуунаас бага оврын хогны машин 2 ширхэг 9,530.0 мянган төгрөгөөр орлого авч Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2024 оны 11 дүгээр сарын 22 -ны өдрийн 2/13 дугаар тогтоолын дагуу хуримтлагдсан элэгдэл нь анхны өртгөө нөхсөн тээврийн хэрэгсэл данснаас 29,500.0 мянган төгрөгийн автомашин, Машин тоног төхөөрөмж данснаас 229.0 мянган төгрөгийн принтер, Тавилга эд хогшил данснаас 4,521.9 мянган төгрөгийн вакуум хаалт, сандлыг акталж устгасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 508,651.4 мянган төгрөг болж, 42,175.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн хуримтлагдсан үр дүнгээр 42,175.8 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл нь 79,527.9 мянган төгрөг болж өмнөх оноос 22,737.1 мянган төгрөгөөр буурсан байна.



3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 18 -ны 12/76 дугаар тогтоолоор тус байгууллагын хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөөг 1,292,900.0 мянган төгрөгөөр баталж, 2024 оны 09 дүгээр сарын 25 -ны өдрийн 16/96 дугаар тогтоолоор 140,000.0 мянган төгрөг нэмэгдүүлэн баталж, Баянхонгор сумын Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 01 -ний өдрийн А/271 дүгээр захирамжаар төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” үүрэгтэй.

Байгууллагын техник, эдийн засгийн гол үзүүлэлт нь Баянхонгор сумын хог хаягдлыг нэгдсэн журмаар ачиж тээвэрлэн нэгдсэн хогийн цэгт хүргэх, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хог хаягдлыг дахин ашиглахтай холбоотой иргэд, аж ахуй нэгж байгууллагын нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэн хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулахтай холбоотой харилцааг зохицуулж, байгаль орчинд ээлтэй цэвэр орчныг бүрдүүлэх явдал юм.

Тайлант онд Бичиг хэргийн материалд 3,633.5 мянган төгрөг, Аж ахуйн материалд 27,669.4 мянган төгрөг, Сэлбэг хэрэгсэлд 78,123.6 мянган төгрөг, Түлш, шатах тослох материалд 276,556.1 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн. Худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

Тус байгууллага нь Баянхонгор сумын 10 дугаар багийн төвийн байранд үйл ажиллагаа явуулдаг тул байр ашиглалттай холбоотой тогтмол зардал гардаггүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Цэвэр хот ОНӨААТҮГ -ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани, түүний орчин, аудитад хамааралтай доторд хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.



Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Дорж гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Цэвэр хот ОНӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 18-ний өдрийн 27 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2024 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор аймгийн Цэвэр хот ОНӨААТҮГ -ын захирал Ц.Баясгалан 2024 оны 12 дугаар сарын 27 -ны өдөр, захирал П.Уртнасан 2024 оны 12 дугаар сарын 28 -ны өдрөөс хойш, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Л.Баттөмөр нар зурсан байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны мөнгөн гүйлгээний тайлангийн үйл ажиллагааны зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны мөнгөн гүйлгээний тайлангийн үйл ажиллагааны зардал 1,445,759.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 14,457.6 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 9,397.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус байгууллага нь төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг тул орон тооны болон тээврийн хэрэгслийн хязгаарлалт үйлчлэхгүй бөгөөд хэмнэлттэй холбоотой заалтуудыг зөрчөөгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”-д заасан орлогын 1,439,000.0 мянган төгрөгийн 13 гүйлгээ, зарлагын 287,396.3 мянган төгрөгийн 17 гүйлгээг, 6.4.8 “Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл”-д заасан 45,729.9 мянган төгрөгийн 55 шийдвэрийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Цэвээнсүрэн гүйцэтгэж, аудитаар 778,800.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 105,799.7 мянган төгрөгийн 3 албан шаардлага өгснийг бүрэн биелүүлсэн талаар FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	105,799.7	3	105,799.7	100
Зөвлөмж	1	778,800.0	1	778,800.0	100
Нийт дүн	4	884,599.7	4	884,599.7	100

Тус компаний өр төлбөр нь өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын үр дүнд 22,737.1 мянган төгрөгөөр буурсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тээвэр шатахууны зардал дээр худалдан авах ажиллагаа зохион байгуулж байх, харилцагч аж ахуй нэгж байгууллага болон иргэдээс и баримтыг шивүүлж анхан шатны баримтын иж бүрдлийг ханган ажиллах, Байгууллагын цахим хуудсыг ашиглалтад оруулж бүртгэл авах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 832.4 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

ХААН банкны дахь 5246 548 905 тоот дансны 2024 оны 12 дугаар сарын 31 - ний үлдэгдэл 832.4 мянган төгрөгийг орлогоор бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 672,342.2 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрснээс 672,342.2 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгөв.

5.1 Албан шаардлага



5.1.1 Тайланд онд 276,556.1 мянган төгрөгийн шатах тослох материал худалдан авахдаа худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1 дэх "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-т заасан хэмжээг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хууль тогтоомжийг дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж байх албан шаардлагыг хүргүүлэв.

5.1.2 Тайлант онд бараа материал худалдан авахдаа 395,786.1 мянган төгрөгийн И баримт шивүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дүгээр зүйлийн 17.6 дахь" Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйлгээний төлбөр тооцоог хийхдээ анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж И баримтыг шивүүлж баримтад хавсаргаж байх албан шаардлага өгч байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайланд онд 276,556.1 мянган төгрөгийн шатах тослох материал худалдан авахдаа худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.	1	276,556.1			1	276,556.1		



Баянхонгор аймгийн Цэвэр хот ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Тайлант онд бараа материал худалдан авахдаа 395,786.1 мянган төгрөгийн И баримт шивүүлээгүй байна.	1	395,786.1			1	395,786.1		
Дүн	2	672,342.2			2	672,342.2		

-----oOo-----

